



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Бөмбөгөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2020/85/СТА-ТШЗ

Цахим хуудас:  
Bayankhongor@audit.gov.mn  
Баянхонгор хот  
2020 он

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга  
бөгөөд тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат  
Утас:70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn  
Аудитын менежер: А.Цээням  
Утас:70444470 Цахим хаяг:tseenyamg@audit.gov.mn  
Аудитор:Д.Энхтуяа  
Утас: 99449299 Цахим хаяг: tomoo\_etuya@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

## Агуулга

Аудитын гэрчилгээ .....	3
Аудитын тайлан.....	5
2.1. Оршил .....	5
2.2. Аудит хийхүндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд: .....	7
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	7
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	9
Шилэн дансны мэдээлэл.....	9
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....	9
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
Менежментийн захидал .....	11
4.1. Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан .....	13
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	14
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	15
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	17
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	18

Аудитын гэрчилгээ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,  
Баянхонгор сум, Номгон баг  
Утас, факс 7044 2584  
E-mail: bayankhongor@audit.gov.mn

Г БӨМБӨГӨР СУМЫН ЕРӨНХИЙ Г  
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ  
Л.НАСАНТОГТОХ ТАНАА

2020.02.27 № 1/286  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т  
Г Аудитын гэрчилгээ Г

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Бөмбөгөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Бөмбөгөр Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Бөмбөгөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

005020254

удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

#### Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

## Аудитын тайлан

### 2.1. Оршил

Бөмбөгөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг сургуулийн захирал Л.Насантогтох танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бөмбөгөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бөмбөгөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020.02.21-нээс 2020.02.23-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020.02.27-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь Глобал капитал аудит ХХК-ны аудитор Д.Энхтуяа хариуцаж хэрэгжүүлэв.

Бөмбөгөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Глобал капитал аудит ХХК-ны газарт 2020.02.19-ны өдрийн 18 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

## **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бөмбөгөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Суралцагчдын сурлагын ахиц амжилтыг дээдлэн, сурах арга барил, төлөвшил хандлагыг эрхэм болгож олон нийтийн оролцоог дэмжихэд оршино” гэсэн эрхэм зорилгыг дэвшүүлэн ажиллаж байна.

Бөмбөгөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Үндэсний болон аймгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллах
- Чанартай, хүртээмжтэй, ахицтай боловсролын үйлчилгээг хүргэх
- Багш, сурагч солилцоо хөтөлбөр боловсруулан ажиллах
- Эцэг эх, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх
- Хүүхдэд ээлтэй эрүүл орчин бүрдүүлэн ажиллах

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Бөмбөгөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Бөмбөгөр сумын Ерөнхий боловсролын сургууль нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Санхүүгийн тооцоолох ХХК-ны Acolouc программ хангамж ашигладаг байна.

Бөмбөгөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитаар Бөмбөгөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 35 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 21 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## **2.7. МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР**

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны 3 дугаар улирлын байдлаарх үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “Их” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2,0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 597956,3 мянган төгрөгөөс тооцон 11959,1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 14096,0 мянган төгрөгөөр тооцсон нь төлөвлөлтийн шатанд сонгосон суурь үзүүлэлтийг өөрчлөөгүйтэй холбоотой болно.

## 2.8. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД:

Бөмбөгөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны жилийн эцсийн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАНГААРХ НИЙТ ХӨРӨНГИЙН дүн өмнөх оноос 4454,3 мянган төгрөгөөр буюу 0,4 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2763,7 мянган, бараа материалын дансны үлдэгдэл 11481,6 мянган төгрөгөөр өссөн материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			-
Авлага	32,2	10000,00	9967,8
Урьдчилгаа			
Бараа материал	74301,9	85783,5	11481,6
Үндсэн хөрөнгө	1220751,5	1223515,2	2763,7
Хуримтлагдсан элэгдэл	-143346,3	-172013,7	-28667,4
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1151739,3</b>	<b>1147285,0</b>	<b>-4454,3</b>
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1151739,3	1147285,0	-4454,3
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1151739,3</b>	<b>1147285,0</b>	<b>-4454,3</b>

Авлага өмнөх оноос 9967,8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарсан ба энэ нь оны эцэст урсгал засварт Елбата ХХК-д шилжүүлсэн урьдчилгаа 10,0 сая төгрөгийг тайланд тусгаснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө 2763,7 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант хугацаанд 31465,2 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, СИТХТ-ын 2019.05.21-ны 13 хурлын тогтоолоор 339 нэрийн 28701,4 мянган төгрөгийн хөрөнгө актлах шийдвэр гарч үндсэн хөрөнгийн данснаас хассан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 11481,6 мянган төгрөгөөр өссөн нь аж ахуйн болон бусад хангамжийн материалын үлдэгдэл нэмэгдсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэлд 4454,4 мянган төгрөгөөр тайлант хугацааны үр дүнгийн өөрчлөлтөөр буурсан байна.

## 2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрт зориулан 684825,3 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 684825,3 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагдсан байна.

Нийт зардлын 643961,1 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээр, Орон нутгийн төсвөөс 40864,2 мянга санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 684825,3 мянган төгрөг буюу 99,6 хувьтай байгаа нь гүйцэтгэлээр 684262,9 мянган төгрөгийг зарцуулж батлагдсан төсвийг 561,4 мянган төгрөгөөр хэмнэж буцаан төвлөрүүлснээс шалтгаалсан байна.

**Нэмэлт төсөв:** Төрийн сангаас нэмэлт санхүүжилтээр орлого ороогүй.

#### 2.11. АУДИТААР ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 7 чиглэлээр 28 эрсдэлд 28 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 4 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 24 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэв.

Аудитаар нийт 32540,0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэнд 15212,2 мянган төгрөгийн зөвлөмж, 17327,8 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоолоо.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал  
(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	2	15212,2	
2	Төлбөрийн акт тогтоосон	2	17327,8	
3	Албан шаардлага өгсөн	0	0.00	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
	Дүн	4	32540,0	

Аудитаар дараах 17327,8 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа зөрчилд төлбөрийн акт, албан шаардлага өгөхөөр шийдвэрлэлээ. Үүнд:

#### 1.Зардлын данстай холбоотой

**Илрүүлэлт:** Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулсан эсэхийг анхан шатны баримтаас түүн горим хэрэгжүүлэх явцад Цалингийн зардлаас байгууллагын багш, ажилтан нарт Сургуулийн захирлын 2019.12.15-ны өдрийн Б43 тоот тушаалаар 7327,8 мянган төгрөгийн түлшний хөнгөлөлт олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-т "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.2- д "Батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргах", Сангийн сайдын 2014 оны 55 дугаар "Эдийн засгийн ангилал батлах тухай" тушаалын "Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах зааврыг баталсан 6 дугаар хавсралт"-ын "Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил" гэсэн төсвийн зарлагын ангиллаас гаргаж холбогдох заалтыг тус тус зөрчсөн байна.

#### Эрсдэл

Батлагдсан төсөв хэтрэх, Төсвийн тухай хууль зөрчигдөх

**Шийдвэрлэсэн нь:**Төлбөрийн акт тогтоов.

БНБ-2020/85/СТА-ТШЗ



## 2. Авлага, өглөгийн данстай холбоотой

**Илрүүлэлт :** Тус байгууллагын харилцах данснаас 2019.12.25-ны өдөр “Элбата” ХХК-ийн дансанд 10 сая төгрөгийг урсгал засварын зардлаас шилжүүлж тайланд авлагаар тусгасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 6.4.8 –т “Төсвийг зохистой удирдаж, авлага , өр төлбөр үүсгэхгүй байх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дүгээр зүйлийн 13,4 дэх “ Аж ахуйн нэгж , байгууллагын гүйцэтгэх удирдлага , нягтлан бодогч нь үйлдвэрлэл үйлчилгээний шат дамжлага , аж ахуйн хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл , өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна “ гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

**Эрсдэл** Батлагдсан төсөв хэтрэх, хөрөнгө үрэгдэх

**Шийдвэрлэсэн нь:** Төлбөрийн акт тогтоов

Аудитаар цалингаас суутгах НДШ, ХХОАТ-аас суутгалуудыг бусад өглөг дансаар дамжуулаагүй , нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримтыг боловсруулж мөрдөөгүй зөрчилд зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

### 2.12. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Байхгүй

#### Шилэн дансны мэдээлэл

Бөмбөгөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг байршуулсан байдал дараах байдалтай байна. Үүнд:

2019 оны мэдээлэл оруулсан байдал дараах байдалтай байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	3	3	5
2	Хагас жил	4	4	3	1	
3	Улирал бүр	4	4	2	2	
4	Сар бүр	36	36	33	3	
5	Тухай бүр	96	96	64	32	
	Нийт	151	151	105	41	5

Нэмэлт зааварчилгаа өгсний улмаас дахин засварлан өөрчлөлт оруулсны улмаас 41 мэдээлэл хугацаа хоцорч мэдээлсэн байна. Цаашид мэдээллийг хугацаанд нь үнэн зөв оруулж байхыг зөвлөв.

### 2.14. ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН АКТ, АЛБАН ШААРДЛАГА, ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар цалингийн программыг ашиглан цалингийн тооцооллыг бүрэн оруулж, санхүүгийн тайланг алдаагүй зөв гаргаж УСНББОУС 1 стандартыг мөрдөж ажиллах гэсэн зөвлөмж өгсөн ба хэрэгжилт 80 хувьтай байна.

## 2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Бөмбөгөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Баацагаан сумын Цэцэрлэгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дахь заалт, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

## **Менежментийн захидал**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

### **1. Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл**

**1.1. Илрүүлэлт.** Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байгууллагын онцлог, үйл ажиллагааг тусгаж боловсруулсан жишиг бичиг баримт байхгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана, 20 дугаар зүйлийн 20.2.2.-т "аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

**1.2. Эрсдэл:** Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох стандартын шаардлага хангаагүй байх

### **1.3. Өгсөн зөвлөмж:**

Нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж, баталж, мөрдөж ажиллах.

**1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** 3 өвлөмжийг хэрэгжүүлж ажиллана

## 2.Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл

### 2.1. Илрүүлэлт:

Нягтлан бодогч цалингийн тооцооны дансны бичилтийг хийхдээ Сангийн сайдын 388-р тушаалаар батлагдсан " " журмын 3.6-ийн б "Байгууллага олговол зохих цалингаас суутган төлөх төлбөрийг тооцож бусад өглөгт шилжүүлэн бүртгэнэ" гэсэн журмыг мөрдөөгүйгээс цалингаас суутгасан НДШ, ХХОАТ-аас бусад суутгалын 15212.2 мянган төгрөгийг "Бусад өглөг"-ийн дансаар бичилт хийлгүй "Цалингийн өглөг" дансанд бичилт хийсэн.

### 2.2. Эрсдэл:

Хууль тогтоомж зөрчиж зардал буруу илэрхийлэгдэх

### 2.3. Өгсөн зөвлөмж:

Цалингаас суутгасан НДШ, ХХОАТ-ын суутгалаас бусад суутгалыг бусад өглөг дансаар дамжуулан бүртгэж Сангийн сайдын 388-р тушаалаар батлагдсан " " журмын 3.6-ийн б "Байгууллага олговол зохих цалингаас суутган төлөх төлбөрийг тооцож бусад өглөгт шилжүүлэн бүртгэнэ" гэсэн заалтыг хэрэгжүүлж, НДШ-ийн зардлыг хуульд заасан хувь хэмжээг харгалзан үзэж бодитой төлөвлөн зардал гаргахдаа Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар"-ыг мөрдөж ажиллах.

.Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 5 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**4.1. Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан**

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

СТ-1А

**САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>74,334,192.77</u></b>	<b><u>95,783,547.56</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	32,242.10	10,000,000.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	32,242.10	00.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	00.00	10,000,000.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	10,000,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	74,301,950.67	85,783,547.56
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	58,922,789.43	67,712,356.70
35110	Тусгай зориулалттай материал	58,922,789.43	67,712,356.70
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	15,139,161.24	18,071,190.86
35420	Аж ахуйн материал	12,174,086.24	15,685,840.86
35440	Түлш, шатах тослох материал	2,870,000.00	00.00
35460	Хүнсний материал	95,075.00	63,850.00
35470	Бусад хангамжийн материал	00.00	2,321,500.00
35600	Мал амьтад	240,000.00	00.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>1,077,405,152.40</u></b>	<b><u>1,051,501,522.09</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,077,405,152.40	1,051,501,522.09
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,043,031,152.40	1,017,127,522.09
39201	Барилга, байгууламж, орон сууц	926,965,873.78	926,965,873.78
39202	Хуримтлагдсан элэгдэл	-14,557,602.60	-34,175,477.40
39203	Авто-тээврийн хэрэгсэл	18,000,000.00	18,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-3,000,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	119,630,280.82	116,950,352.10
39206	Хуримтлагдсан элэгдэл	-85,156,956.23	-86,554,116.60
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	93,815,942.90	99,084,365.90
39208	Хуримтлагдсан элэгдэл	-43,181,741.33	-47,834,131.95
39217	Ном	27,515,355.06	27,690,656.26
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	34,374,000.00	34,374,000.00
39301	Програм хангамж	450,000.00	450,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-450,000.00	-450,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	34,374,000.00	34,374,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>1,151,739,345.17</u></b>	<b><u>1,147,285,069.65</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>1,151,739,345.17</u></b>	<b><u>1,147,285,069.65</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,151,739,345.17	1,147,285,069.65
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	433,663,308.00	433,663,308.00
51101	Өмч: - төрийн	433,663,308.00	433,663,308.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	229,649,855.75	225,195,580.23
51210	Өмнөх үеийн үр дүн	229,649,855.75	229,649,855.75
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-4,454,275.52
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	488,426,181.42	488,426,181.42
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>1,151,739,345.17</u></b>	<b><u>1,147,285,069.65</u></b>

**4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

СТ-2А

**САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>599,517,493.00</b>	<b>700,348,741.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>22,364,717.00</b>	<b>15,523,441.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>22,364,717.00</b>	<b>15,523,441.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	22,364,717.00	15,523,441.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	90,000.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	22,274,717.00	15,523,441.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>17,474,176.00</b>	<b>40,864,200.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төсвөөс санхүүжих</b>	<b>559,678,600.00</b>	<b>643,961,100.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	559,678,600.00	643,961,100.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>4,842,887.00</b>	<b>00.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,842,887.00	00.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>00.00</b>	<b>40,864,200.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	40,864,200.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>12,631,289.00</b>	<b>00.00</b>
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	12,631,289.00	00.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>614,108,019.18</b>	<b>692,384,265.40</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>614,108,019.18</b>	<b>692,384,265.40</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>526,332,574.18</b>	<b>664,811,689.40</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>366,479,711.00</b>	<b>478,104,000.10</b>
210101	Үндсэн цалин	271,319,111.00	418,815,000.10
210102	Нэмэгдэл	44,577,700.00	27,934,700.00
210104	Урамшуулал	22,662,200.00	19,129,200.00
210105	Гэрээт ажлын хөлс	27,920,700.00	12,225,100.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>51,822,500.00</b>	<b>64,334,298.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	40,044,600.00	45,160,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,944,400.00	5,381,598.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,363,400.00	3,746,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	581,000.00	913,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,889,100.00	9,132,800.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>29,950,944.00</b>	<b>36,833,218.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	5,460,944.00	5,752,018.00
210302	Түлш, халаалт	23,890,000.00	30,975,200.00
210303	Цэвэр, бохир ус	600,000.00	106,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>10,000,803.00</b>	<b>9,836,300.00</b>
210401	Бичиг хэрэг	937,200.00	2,401,200.00

**Бөмбөгөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210402	Тээвэр, шатахуун	1,504,200.00	2,234,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	641,000.00	1,934,800.00
210404	Ном, хэвлэл	628,400.00	431,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	105,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	843,400.00	2,729,800.00
210408	Бараа материал акталсны зардал	5,446,603.00	00.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>15,896,875.00</b>	<b>14,862,475.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	216,500.00	541,100.00
210502	Хоол, хүнс	15,161,275.00	13,337,675.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	519,100.00	983,700.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2,526,700.00</b>	<b>3,160,000.00</b>
210604	Урсгал засвар	2,526,700.00	3,160,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>448,000.00</b>	<b>2,068,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	448,000.00	2,068,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>5,160,987.00</b>	<b>1,192,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,160,987.00	792,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	400,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>44,046,054.18</b>	<b>54,421,398.30</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,302,200.00	6,056,778.11
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,518,100.00	3,414,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	35,225,754.18	44,950,120.19
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>87,775,445.00</b>	<b>27,572,576.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>87,545,889.00</b>	<b>27,011,200.00</b>
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	12,631,289.00	00.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	25,569,600.00	23,059,200.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	32,273,200.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	16,729,800.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	342,000.00	3,952,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>00.00</b>	<b>982.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	982.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>229,556.00</b>	<b>560,394.00</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	229,556.00	560,394.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-14,590,526.18</b>	<b>7,964,475.60</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,179,179.90</b>	<b>12,418,751.12</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	12,418,751.12
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	1,179,179.90	00.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>-1,179,179.90</b>	<b>-12,418,751.12</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-15,769,706.08</b>	<b>-4,454,275.52</b>

**4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

СТ-2А

**МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>577,242,776.00</b>	<b>684,825,300.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>90,000.00</b>	<b>00.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>90,000.00</b>	<b>00.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	90,000.00	00.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	90,000.00	00.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>577,152,776.00</b>	<b>684,825,300.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төсвөөс санхүүжих</b>	<b>559,678,600.00</b>	<b>643,961,100.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	559,678,600.00	643,961,100.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>4,842,887.00</b>	<b>00.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,842,887.00	00.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>00.00</b>	<b>40,864,200.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	40,864,200.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>12,631,289.00</b>	<b>00.00</b>
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	12,631,289.00	00.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>577,242,776.00</b>	<b>684,825,300.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>577,242,776.00</b>	<b>684,825,300.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>489,467,331.00</b>	<b>657,252,724.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>366,373,362.00</b>	<b>478,980,356.00</b>
210101	Үндсэн цалин	271,212,762.00	337,448,556.00
210102	Нэмэгдэл	44,577,700.00	70,789,300.00
210104	Урамшуулал	22,662,200.00	39,395,500.00
210105	Гэрээт ажлын хөлс	27,920,700.00	31,347,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>51,822,500.00</b>	<b>63,425,700.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	37,710,600.00	45,160,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,528,000.00	4,566,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,822,300.00	3,653,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	705,700.00	913,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,055,900.00	9,132,800.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>32,276,392.00</b>	<b>34,363,218.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	3,750,992.00	3,753,218.00
210302	Түлш, халаалт	27,425,400.00	29,510,000.00
210303	Цэвэр, бохир ус	1,100,000.00	1,100,000.00

**Бөмбөгөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>4,686,500.00</b>	<b>17,339,400.00</b>
210401	Бичиг хэрэг	937,200.00	2,272,200.00
210402	Тээвэр, шатахуун	1,504,200.00	1,704,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	641,000.00	2,645,800.00
210404	Ном, хэвлэл	616,000.00	2,717,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	180,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	988,100.00	7,819,800.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>15,950,890.00</b>	<b>14,701,250.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	216,500.00	541,100.00
210502	Хоол, хүнс	15,215,290.00	13,066,450.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	519,100.00	1,093,700.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>3,526,700.00</b>	<b>28,750,000.00</b>
210602	Тавилга	00.00	12,250,000.00
210604	Урсгал засвар	3,526,700.00	16,500,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>448,000.00</b>	<b>2,068,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	448,000.00	2,068,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>5,320,987.00</b>	<b>1,192,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,320,987.00	792,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	400,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>9,062,000.00</b>	<b>16,432,800.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,441,500.00	8,700,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,620,500.00	7,732,800.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>87,775,445.00</b>	<b>27,572,576.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>87,545,889.00</b>	<b>27,011,200.00</b>
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	12,631,289.00	00.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	25,569,600.00	23,059,200.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	32,273,200.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	16,729,800.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	342,000.00	3,952,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>00.00</b>	<b>982.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	982.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>229,556.00</b>	<b>560,394.00</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	229,556.00	560,394.00
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>

#### 4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН					СТ-4А
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/ төгрөгөөр / Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	399,289,308.00	00.00	245,401,418.73	644,690,726.73
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	399,289,308.00	00.00	245,401,418.73	644,690,726.73
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	34,374,000.00	00.00	-15,769,706.08	18,604,293.92
C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	433,663,308.00	488,426,181.42	229,649,855.75	1,151,739,345.17
D01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	433,663,308.00	488,426,181.42	229,649,855.75	1,151,739,345.17
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	433,663,308.00	488,426,181.42	229,649,855.75	1,151,739,345.17
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-4,454,275.52	-4,454,275.52
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	433,663,308.00	488,426,181.42	225,195,580.23	1,147,285,069.65

#### 4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	477,319,400.00	472,349,980.00	684,825,300.00	684,263,924.00
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	477,319,400.00	472,349,980.00	684,825,300.00	684,263,924.00
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	445,792,300.00	442,159,980.00	657,321,700.00	657,252,724.00
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	347,406,200.00	347,387,850.00	476,205,600.00	478,980,356.00
210101	Үндсэн цалин	249,488,400.00	246,420,928.00	334,673,800.00	337,448,556.00
210102	Нэмэгдэл	40,536,200.00	43,585,322.00	70,789,300.00	70,789,300.00
210104	Урамшуулал	29,460,900.00	29,460,900.00	39,395,500.00	39,395,500.00
210105	Гэрээт ажлын хөлс	27,920,700.00	27,920,700.00	31,347,000.00	31,347,000.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	38,214,800.00	38,214,800.00	63,425,700.00	63,425,700.00
210201	Тэтгэврийн даатгал	38,214,800.00	38,214,800.00	45,160,000.00	45,160,000.00
210202	Тэтгэмжийн	00.00	00.00	4,566,600.00	4,566,600.00

**Бөмбөгөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

	даатгал				
210203	YOMШӨ-ний даатгал	00.00	00.00	3,653,200.00	3,653,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	00.00	913,100.00	913,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	00.00	9,132,800.00	9,132,800.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	27,031,000.00	27,031,000.00	34,364,200.00	34,363,218.00
210301	Гэрэл, цахилгаан	2,254,200.00	2,254,200.00	3,754,200.00	3,753,218.00
210302	Түлш, халаалт	23,870,800.00	23,870,800.00	29,510,000.00	29,510,000.00
210303	Цэвэр, бохир ус	906,000.00	906,000.00	1,100,000.00	1,100,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	5,804,000.00	5,800,230.00	20,139,400.00	17,339,400.00
210401	Бичиг хэрэг	962,500.00	962,500.00	2,272,200.00	2,272,200.00
210402	Тээвэр, шатахуун	1,464,700.00	1,464,700.00	1,704,200.00	1,704,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,875,400.00	1,871,630.00	2,645,800.00	2,645,800.00
210404	Ном, хэвлэл	362,100.00	362,100.00	2,717,400.00	2,717,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	00.00	180,000.00	180,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,139,300.00	1,139,300.00	10,619,800.00	7,819,800.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	17,213,500.00	13,605,700.00	14,742,600.00	14,701,250.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	246,900.00	246,900.00	541,100.00	541,100.00
210502	Хоол, хүнс	16,723,600.00	13,091,800.00	13,107,800.00	13,066,450.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	243,000.00	267,000.00	1,093,700.00	1,093,700.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,326,000.00	1,326,200.00	28,750,000.00	28,750,000.00
210602	Тавилга	00.00	00.00	12,250,000.00	12,250,000.00
210604	Урсгал засвар	1,326,000.00	1,326,200.00	16,500,000.00	16,500,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	743,000.00	740,400.00	2,069,400.00	2,068,000.00
210702	Дотоод албан томилолт	743,000.00	740,400.00	2,069,400.00	2,068,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	713,200.00	713,200.00	1,192,000.00	1,192,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	713,200.00	713,200.00	792,000.00	792,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	00.00	400,000.00	400,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	7340600.00	7340600.00	16432800.00	16432800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,340,600.00	7,340,600.00	8,700,000.00	8,700,000.00

Бөмбөгөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	00.00	7,732,800.00	7,732,800.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	31527100.00	30190000.00	27503600.00	27011200.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	31,527,100.00	30,190,000.00	27,503,600.00	27,011,200.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	25,052,500.00	23,715,400.00	23,551,600.00	23,059,200.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	6,474,600.00	6,474,600.00	00.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	00.00	3,952,000.00	3,952,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	477,319,600.00	477,019,600.00	684,825,300.00	684,263,924.00
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	477,019,600.00	477,019,600.00	643,961,100.00	643,400,706.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	477,019,600.00	477,019,600.00	643,961,100.00	643,400,706.00
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	00.00	00.00	40,864,200.00	40,863,218.00
132001	Орон нутгийн төсвөөс	00.00	00.00	40,864,200.00	40,863,218.00
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	300,000.00	00.00	00.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	300,000.00	00.00	00.00	00.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	49	49	49	49
620001	Удирдах ажилтан	03	03	03	03
620002	Гүйцэтгэх ажилтан	28	28	28	28
620003	Үйлчлэх ажилтан	18	18	18	18

**АУДИТЫН ТАЙЛАНГ:**

БЭЛТГЭСЭН: АУДИТОР

Д.ЭНХТУЯА

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

А.ЦЭЭНЯМ *2020.02.27*

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:  
ДАРГА ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ

